



ДУНДГОВЬ АЙМАГ  
САЙНЦАААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар A/362

Мандалговь

Г Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "ж", Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх хэсэг, аймгийн засаг даргын 2020 оны А/362 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Коронавирус (Ковид-19)-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасан тул сумын хэмжээнд соёл, урлаг, спорт болон олон нийтийг хамарсан бүх төрлийн үйл ажиллагааг 2020 оны 12 дүгээр сарын 11-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэл хугацаанд хориглосугай.

Хоёр. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан сумын Онцгой комиссын жижүүрийн хуваарийн шинэчлэн, хавсралтаар баталж, 2020 оны 12 сарын 14 ний өдрөөс ажиллуулсугай.

Гурав. Засгийн газар болон аймаг, сумын онцгой комиссын шийдвэрүүдийг хэрэгжүүлж, халдварт хамгааллын журам, дэглэмийг байнга мөрдөхийг голомтын бус нутгаас ирж, гэрийн ажиглалтанд байгаа болон сумын нийт иргэдэд үүрэг болгосугай.

Дөрөв. Голомтын бус нутгаас ирж, гэрийн ажиглалтанд байгаа иргэд, тэдний ар гэрийнхэнд тавих хяналтыг сайжруулж, иргэдийг зөвлөмж, мэдээллээр хангахыг сумын ЭМТөвийн албан хаагчид, харьяа байгууллагын удирдлагууд, багийн засаг дарга, багийн нийгмийн ажилтнуудад даалгасугай.

Тав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын засаг даргын орлогч /О.Баярсайхан/, ЗДТГазрын дарга /Б.Оюунчимэг/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ